

**“Erasmus” төслийн Эко Ази дээд сургуулийн багийн
ээлжит онлайн хурлын тэмдэглэл**

2021 оны 06 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

**ТХГН-ИЙН экосистемийн үйлчилгээний менежментийн чиглэлээр магистрын
сургалтын хөтөлбөр боловсруулах төслийн Улан-Удэд зохион байгуулагдах
анхдугаар хурлын сэдэв болох “Магистрын сургалтын хөтөлбөрийн
хэлэлцүүлэг” талаар**

Хурал хийсэн газар: Хурлыг google meet ашиглан <https://meet.google.com/ooz-sabw-scd> линкээр хийлээ. Хурлыг 09:10 цагт эхэлж, 10:10 цагт дуусгав.

Хэлэлцэх асуудал: Магистрын сургалтын хөтөлбөр урьдчилсан байдлаар А.Эрдэнэбаяр бэлтгэж танилцуулна.

Хуралд оролцсон:

ЭКО АЗИ БОМДС-ийн Ерөнхий захирал Ц.Адъяасүрэн, ерөнхий менежер А.Эрдэнэбаяр, эрдмийн зөвлөлийн гишүүн Д.Энэбиш, эрдмийн зөвлөлийн гишүүн Б.Мижиддорж, ахлах багш Э.Доржпагма нар оролцов.

Хэлэлцсэн нь:

1. А.Эрдэнэбаяр магистрын сургалтын хөтөлбөрийг урьдчилсан байдлаар 2 хэлбэрээр бэлтгэж танилцуулав. 1-р хувилбар БСШУЯ хүлээн зөвшөөрдөг хэлбэр 2-р хувилбар ЕХ-ны Erasmus+ төслөөс санал болгож буй хэлбэр болох модуль хэлбэр. Урьдчилсан хөтөлбөр боловсруулахдаа А-174 сургалтын төлөвлөгөөг ашигласан мөн ЕХ-ны Erasmus+ төслийн хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнг оруулсан болно.

Шийдвэрлэсэн нь:

1. Б.Мижиддорж: Зэрлэг амьтан хамгаалах, нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авах нь ТХГН-ын маш чухал хэсгийн нэг учраас модульд оруулахыг дэмжив.
Ц.Адъяасүрэн: Тооллого мониторинг хийх, харилцааны ёс зүйд сургах чиглэлийг мөн оруулахыг санал болгов.
2. Д.Энэбиш: Сүүлийн үед алив сургалтын хөтөлбөрийг чадамжинд суурилан боловсруулах шаардлага тавьдаг болсон байна. Бид 2011 онд байгаль хамгаалагчдын сургалтын хөтөлбөр боловсруулахдаа хангай говь хээрийн бүсийн 50 шахам байгаль хамгаалагчийн өдөр тутмын гүйцэтгэдэг ажлын судалгааг авч тэр үйл хэргийг гүйцэтгэхэд шаардагдах чадамжийг онол практикийн түвшинд олгох хөтөлбөрийг боловсруулж байлаа. Ер нь алив

сургалтын хөтөлбөрийг чадамжинд суурилан боловсруулахыг сүүлийн үед чухалчлах болсон байна. Иймд энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа өмнө хийгдсэн судалгаандаа түшиглэж олгох чадамжийг урьдчилан тооцох хэрэгтэй.

Монгол улсад сүүлийн 10 жилд олон улсад мөрдөгдөж буй аргазүйн дагуу 10 шахам газарт бүс нутгийн экосистемийн үйлчилгээг үнэлж дэлгэрэнгүй тайлан бичигдсэн байна. Тэдгээр тайланд экосистемийн үйлчилгээг экосистемийн бүрдэл хэсэг тус бүрээр мөнгөн дүнгээр үнэлж тооцсон байна. Тухайлбал “Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын экосистемийн үйлчилгээний үнэ цэнэ: судалгааг Г.Ганзориг Г.Энх-Амгалан, О.Амартүвшин, Ш.Дэнсмаа, Ц.Гантулга нар гүйцэтгэж цаашдын чиг хандлагыг хоёр хувилбараар нарийвчлан тооцож холбогдох арга хэмжээг төлөвлөсөн байна. Иймд энэ үнэлгээг хийсэн аргазүйг холбогдох газруудаас олж сургалт судалгааны ажилдаа нэвтрүүлэх шаардлагатай байна.

Ц.Адъяасүрэн: энэ талаар ТНС-ын Ю.Баяржаргалтай холбогдож материал олъё.

3. Магистрын хөтөлбөрт цогц чадамжийн талаар оруулна. Ингэхдээ гишүүн бүрд хамрах сэдвээр хувиарлалт хийв.

Д.Энэбиш-Ой

Б.Мижиддорж-Амьтан

А.Эрдэнэбаяр-Ус

Ц.Адъяасүрэн-Ургамал

Э.Доржпагма-Хөрс, намаг

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Э.ДОРЖПАГМА

ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН :

Ц.АДЪЯАСҮРЭН